

ЯПОН, ЗХУ-ЫН ХАРИЛЦАА БА ӨВӨР МОНГОЛ

ГАНБАГАНА

*Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн
Монгол судлалын дээд сургуулийн профессор*

Товч агуулга: Тус өгүүлэлд газар зүйн байрлалаасаа хамаарч, Монголын асуудалд ихээхэн нөлөө үзүүлж ирсэн Япон, ЗХУ хоёр улсын харилцааны түүхэн дэх Халхын сүмийн хэрэг, Халх голын дайн, Дөрвөн улсын холбооны онол, ЗХУ-Японы төвийг сахих гэрээ зэрэг түүхэн хэрэг явдлуудын монголын Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн нөлөө тусгал, утга агуулгын талаар задлан шинжилж тухайн үеийн олон улсын харилцаан дахь Өвөр Монголын асуудлын мөн чанарыг тодруулсан байна.

Түлхүүр үг: Өвөр Монгол, олон улсын харилцаа, Халхын сүмийн хэрэг, Халх голын дайн, ЗХУ – Японы төвийг сахих гэрээ

1930-1940-өөд оны хооронд өрнөсөн Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөн нь цар хүрээ, нөлөө тусгал, хугацаа зэрэг аль аль талаас нь авч үзсэн орчин үеийн Өвөр Монголын түүхэнд урьд өмнө байгаагүй томоохонд хөдөлгөөн байсан бөгөөд ойролцоогоор арав гаран жил үргэлжилж эцэстээ ялагдлаар төгссөн байдаг. Тэгвэл энэхүү улс төрийн том хэрэг явдал нь яагаад ийм үр дүнгээр төгссөн бэ? Түүний шалтгаан нь чухам юу вэ? Өнөөг хүртэл хараахан тайлбараа олж чадаагүй эдгээр асуудлын талаар маш олон талын үзэл хандлага байж болох бөгөөд өөр өөр байр сууринаас янз бүрийн дүн шинжилгээ гаргах боломжтой ч тухайн үеийн Өвөр Монголын гадаад нөхцөл байдал, дэлхийн улс төрийн байдлыг задлан шинжихгүйгээр бүрэн гүйцэд хариулыг өгч чадна гэдэгт миний бие жаахан эргэлзээтэй байна. Учир нь тухайн үед Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөний үндэс сууринд олон улсын байдал гэх ойшоохгүй байхын аргагүй том асуудал байсан бөгөөд тэр нь хаашаа чиглэх вэ? гэдгээс шалтгаалан, Өөртөө засах хөдөлгөөний чиглэл өөрчлөгдөж, зарим тохиолдолд бүр ч хувь заяагаа шийдвэрлүүлж байсан юм.

Гэвч харамсалтай нь өнөөг хүртэл судалгаанд олон улсын гадаад харилцааны үүднээс уг асуудлын талаар судалсан бүтээл бараг байхгүй гэж хэлж болно. Зохиогч миний бие ч гэсэн Япон Хятад¹ буюу Япон Америкийн² харилцааны талаас энэ асуудлын тухай задлан шинжилгээ хийж байсан ч газарзүйн байрлалаасаа

¹ Ганбагана 「モンゴル自治邦の実像と虚像」『中国21』（27）、2007年。

² Ганбагана 「内モンゴル自治運動と太平洋戦争期における日本の対内モンゴル政策について—「日華同盟条約」を中心に」『東北アジア研究』（16）、2012年。

хамаарч Монголын асуудалд ихээхэн нөлөө үзүүлж ирсэн Япон, ЗХУ хоёр улсын харилцааны үүднээс судалж байгаагүй юм. Тиймээс энэхүү өгүүлэлдээ Япон, ЗХУ хоёр улсын харилцаанд тулгуурлан уг асуудлын талаар дүн шинжилгээ хийнэ.

Тодруулж хэлбэл 1931 оны 9 сарын 18-ий хэрэг хувьслын дараа Японы арми нь удалгүй Манжуур (Хятадын зүүн хойд орон)-ын нутгийг эзэлж түүнээс үүдэлтэйгээр Япон-ЗХУ-ын харилцаанд сэв сууж, улмаар Халхын сүмийн хэрэг зэрэг хилийн маргаан тасралтгүй гарах болжээ. Өвөр Монгол нь Япон улсын гадаад бодлогот “Коммунизмыг сэргийлэх” түшиц газар болж удалгүй Монгол цэргийн засгийн газар байгуулагдах болсон нь чухам энэ үе юм. Эдгээр хилийн маргаанууд эцэстээ Халх голын дайн болон илэрч улмаар Японы уалагдал ба Зөвлөлт, Германы “Харилцан үл довтлох гэрээ” зэрэг олон улсын нөхцөл байдлаас шалтгаалан Японы олон улсад баримтлах стратеги нь “Умард зүг дайлах бодлого”-оос “Өмнө зүг дайлах бодлого” зүг шилжсэн байна. Үүний дараа Японы гадаад бодлогод Гадаад хэргийн сайд Мацуока Ёсэки (松岡洋右)-ийн “Дөрвөн улсын холбооны онол” гарч үр дүнд нь “ЗХУ-Японы төвийг сахих гэрээ” байгуулагджээ. Мацуока нь тухайн үед хэлэлцээр хийж байхдаа ЗХУ-ын Гадаад хэргийн сайд Молотовт хандан Япон Улс нь ЗХУ-ын Гадаад Монгол, Шинжаан дахь нөлөөллийн хүрээг зөвшөөрсний хариуд ЗХУ нь Японы Өвөр Монгол, “Хойд Хятад” дахь нөлөөний хүрээг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж шаардсан боловч Молотов түүнийг нь зөвшөөрөөгүй байна. Нөгөө талаар Японы “Өмнө зүг дайлах бодлого”-оос шалтгаалж, Зүүн Өмнөд Азийн бүс нутаг дахь үндэстний тусгаар тогтнолын хөдөлгөөн эрчимжиж эцэст нь тусгаар тогтнолоо олсон байдаг.

Тус өгүүлэлд Япон-ЗХУ-ын харилцааны түүхэн дэх эдгээр хэрэг явдлуудын Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн нөлөө тусгал, утга агуулгын талаар задлан шинжиж тухайн үеийн олон улсын харилцаан дахь Өвөр Монголын асуудлын мөн чанарыг тодруулна. Гэхдээ Өөртөө засах хөдөлгөөний талаар миний бие хэд хэдэн өгүүлэл өмнө нь хэвлүүлсэн учир энэхүү өгүүлэлд дэлгэрэнгүй бичээгүй болно.

1. Япон-ЗХУ-ын хилийн мөргөлдөөн болон Коммунизмын эсрэг түшиц газар болсон Өвөр Монгол

1.1. Халх сүмийн мөргөлдөөн болон Манжуурын хэлэлцээр

1905 оны Портсмут буюу Орос-Японы нууц гэрээнд Манж- Монголын газар нутаг дахь Япон, Оросын тус тусын нөлөөний хүрээг тогтоосон бөгөөд түүний дараа Ишихара Канжи (石原莞爾) зэрэг Квантуны армийн командлагчдын нэг бүлгийнхний “Манж-Монголын орныг эзлэх” төлөвлөгөөгөөр шинэ эргэлт гарсан байна. Ишихара нь “Манж-Монголын асуудлын тухай” хэмээх лекцэдээ “Хойд Манжуурт Оросын нөлөө байгаа цагт Япон Улсын батлан хамгаалалтыг аюулгүй хэмээн үзэхгүй. Манж- Монголын асуудал нь бүрэн шийдэгдэн Хойд Манжуурт Японы нөлөө бий болсон цагт Хар мөрний Да Хө-гээс Их Хянганы нуруу хүртэлх шугам манай улсын батлан хамгаалах өмнөх фронт болж Өвөр Монголын Хөлөнбуйрын тал нутагтай нүүрлэх болно. Тэгвэл Орос нь цэргийн хүчээр довтлоход бэрх болох тул довтлохоо бараг зогсооно” гэж үзсэн байна³.

³ 小林幸男『日ソ政治外交史—ロシア革命と治安維持法』、有斐閣、1985年、p. 65

1931 оны 9 сарын 18-ны “Манжийн хэрэг”-ийн дараа Квантуны арми төлөвлөгөө ёсоор Хойд Манжуурыг эзэлж дараа жил нь Манж Улсыг байгуулав. Ингээд Оросын ашиг сонирхлын хэсэгт байсан “Хойд Манжуур”, ялангуяа Оросын эзгнэж ирсэн “Дорнод Хятадын төмөр зам”-д Квантуны арми хөндлөнгөөс орж ирсэн нь Орос-Японы дайнаас хойших уламжлалт харилцаанд ноцтой нөлөөлсөн байна⁴. 1933 оны 3 сард Япон “Дорнод Хятадын төмөр зам” болон Сибирийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөн, 5 сард Зүүн хойд хилийн боомтыг тус тус хааж, Манжуурыг бүхэлд нь эзэлсэн байна. Өмнө нь Жан Шүэлян (张学良)-ийн эрхшээлийн үед ийм хэрэг гарахад ЗХУ цэргийн хүчээр шийдвэрлэж байсан бол энэ удаа тэгсэнгүй, харин Москва дахь Японы элчин сайдын яамаар дамжуулан хэлэлцээрээр шийдвэрлэхийг зорьсон байна. Эцэстээ 1935 оны 3 сард Зөвлөлт нь “Дорнод Хятадын төмөр зам”-ыг 17 сая иенээр Манж Улсад (Японы байгуулсан Манжго улсыг зааж буй. Хойш адил бичнэ) өгсөн байна⁵. Ишихарагийн төлөвлөсөн Манж-Монголын газрыг эзэмших төлөвлөгөө нь дээрхийн адил биелэгдэв. Үүний зэрэгцээ Япон-Зөвлөлтийн харилцаа хурцдаж, тэр нь ихэвчлэн хилийн мөргөлдөөнөөр дамжин илэрч байв.

Квантуны армийн судалгаагаар, Зөвлөлт-Манжийн хилийн мөргөлдөөн 1932-1934 оны хооронд 152 удаа гарч байсан бол 1935 онд 176 удаа, 1936 онд 152 удаа, 1937 онд 113 удаа, 1938 онд 166 удаа гэх мэт 1935 оноос хойш огцом нэмэгдсэн нь харагдаж байна⁶. Үүний сацуу, Манж Улс болон Монгол Улсын хилийн ойролцоо ч үүнтэй адил мөргөлдөөн олон гарч байв. Бидний сайн мэдэх Халхын сүмийн мөргөлдөөн 1935 оны 1 сарын 08-нд болсон байдаг.

Халхын сүмийн мөргөлдөөний дараа энэ мэт хилийн маргааныг багасгахын тулд Японы Гадаад Хэргийн Яамны саналаар Манж-Монгол Улсын хооронд Манжуурын хэлэлцээр болж, 1935 оны 6 сарын 03-аас 1937 оны 11 сарын 15-ны хооронд нийтдээ дөрвөн удаа хуралдсан байна. Эхний хуралд Манж Улсын талаас Хойд Хянган мужийн захирагч Лин Шөн, Хойдыг хамгаалах цэргийн Ерөнхий командлагч, хошууч генерал Уржин, Гадаад хэргийн яамны улс төрийн зөвлөлийн гишүүн Канки Шёоичи (神吉正一) нарын 12 хүн, Монголын талаас Бүх цэргийн жанжны орлогч Г.Самбуу, Дорнодын хоёрдугаар морьт корпусын дарга Г.Дамба, Засгийн газрын түшмэл Д.Догсом нарын 8 хүн тус тус төлөөлөгчөөр оролцжээ⁷. Гэвч хэлэлцээр тодорхой үр дүнд хүрч чадаагүй. Түүний шалтгаан нь тухайн үед дорно дахины асуудалд шийдвэрлэх нөлөө үзүүлж байсан Япон-Зөвлөлтийн аль аль нь хилийн асуудлаар харилцан буулт хийх санаа огт байгаагүйтэй холбоотой⁸.

Манжуурын хэлэлцээрийн дүнд Япон-Зөвлөлтийн харилцаа улам муудаж, хоёул цэргийн хүчээ нэмэгдүүлж эхэлсэн бөгөөд Зөвлөлт нь эхэндээ Манжуурт байрлах Япон, Манжийн цэрэгтэй харьцуулахад түүний талд нь ч хүрэхгүй байсан хил орчмын цэргийн хүчээ нэмэгдүүлсэн байна. Цэргийн хүч нь 1936 оны

⁴ 酒井哲哉「日米開戦と日ソ関係」、細谷千博ほか編 『太平洋戦争』東京大学出版会、1993年、p.134。

⁵ 判澤純太「ノモンハン事件と国際環境」『政治経済史学』（252）、1987年、pp.3-5。

⁶ 防衛庁防衛研修所戦史室『関東軍1』（対ソ戦備・ノモンハン事件）朝雲新聞社、1969年、p.310

⁷ マンダフ・アリウンサイハン「満洲里会議に関する一考察」『一橋論叢』（778）、2005年、p.116。

⁸ Мөн тэнд. p.128.

байдлаар мэргэн буудагчийн 16 дивиз, морин цэргийн 3 дивиз, танк 1200, нисэх онгоц 1200, шумбагч онгоц 30 нийтдээ 290 мянган цэрэг байсан бол 1937 онд 50 мэргэн буудагчийн дивиз 1.5 сая цэрэг байв. Цэргийн төсөв нь 1935 онд 1 тэрбум 400 сая рубль байсан бол 1936 онд 4 тэрбум рубль болсон байна⁹. Гадаад Монголын хилийн ойр Байгаль нуурын цэргийн бааз байгуулсан нь ч энэ үед таарч байлаа.

Монгол Улс (БНМАУ) ч хилийн аюулгүй байдлаа хангаж, Манжуурын баруун хэсгийн нутаг Хэрэмтээс Халхын сүм хүртэлх хилээ чангатгаж, Буйр нуурын баруун хэсэгт цэргийн бааз байрлуулсан байв. Мөн батлан хамгаалах төсвөө нэмж, цэргийн алба хаах хугацааг 30 хувь, цэргийн хэрэгслийг 40 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргажээ. 1934 оны 11 сарын 27-нд Монгол Улсын шаардлагаар цэргийн түрэмгийлэл болох юм бол харилцан тусална гэсэн агуулга бүхий “Монгол-Зөвлөлийн аман хэлэлцээр байгуулагдав¹⁰. Улмаар 1936 оны 3 сарын 12-нд Монголын нийслэл Улаанбаатарт аль нэг гуравдагч улсаас тухайн хоёр улс руу дайрсан тохиолдолд зэвсэгт хүчнээр харилцан туслалцана гэсэн “Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах протокол”-г байгуулж, цэргийн хүчээ улам чангатгажээ.

Японы тал уг гэрээг Япон, Манж хоёр улсад зарласан дайны зар гэж маш ноцтойгоор хүлээн авсан байна. ЗХУ ч энэ тал дээр өөрийн гэсэн бэлтгэлтэй байв. 1936 оны 3 сарын 01-нд Кремльд Япон-Зөвлөлтийн харилцааны тухай асуудалд Сталин, “Хэрэв Япон Монгол руу дайрч, тус улсын тусгаар тогтнолын эсрэг үйлдэл гаргасан тохиолдолд Зөвлөлт нь Монгол Улсад тусална. Зөвлөлтийн засгийн газар 1921 онтой адил арга хэмжээ авах болно. Япон нь Улаанбаатарыг эзлэхийг горьдож байгаа байх” хэмээн хариулж Японыг шүүмжилсэн байдаг¹¹. Дээр дурдсан 1921 он гэдэг нь улаан цэрэг Гадаад Монголд нэвтрэн орж Барон Унгерныг хөөн Гадаад Монголыг ЗХУ-ын мэдэлд оруулсан жил бөгөөд адил арга хэмжээ авна гэдэг нь Японтой дайн хийх гэсэн утгыг илэрхийлж байв¹².

Энэ мэтээр Япон нь Манж Улсыг өөрийн “Тоглоомын улс” болгож, ЗХУ нь Монгол Улсыг өөрийн “Дагуул улс”-аа болгосноос болж Япон, Зөвлөлт хоёр улс хилээр шууд залгах болжээ. Өнөөг хүртэлх “бамбай бүсийн нутаг” хэмээгдэж байсан эдгээр бүх нутгууд нь оршихын ач холбогдлоо алдаж, үлдсэн нь зөвхөн зэвсэгт мөргөлдөөн гэх ганцхан сонголт байв. Ингээд Япон-Зөвлөлтийн хооронд тэмцлийн шинэ тавцан болон гарч ирсэн нь тухайн үед өртөө засах хөдөлгөөн өрнөөд байсан Өвөр Монголын баруун нутаг байсан бөгөөд Квантуны армийн “Өвөр Монголын ажиллагаа” яг тухайн үед эхэлсэн байдаг. Квантуны армийн штабын дарга Итагаки Сэйшироү нь Бүх цэргийн удирдагчдын хурал дээр нэлээд урт илтгэл тавьж, “Өвөр Монголын засгийн газрыг байгуулж, улмаар Монгол үндэстнийг нэгтгэн, тусгаар тогтносон Монгол Улсыг байгуулах” тухай Квантуны армийн бодлогыг ярьж байсан нь ч энэ үе билээ¹³.

Өөрөөр хэлбэл, Халхын сүмийн мөргөлдөөнөөр төлөөлүүлсэн Япон-Зөвлөлтийн хилийн маргаан нь Японы баруун тийш нэвтрэн орохыг идэвхжүүлэн тэр нь цаашлаад Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөнд түлхэц хүчин өгсөн гэж хэлж болно.

⁹ Өмнө дурьдсан 「ノモンハン事件と国際環境」、р. 6.

¹⁰ 牛島康允『ノモンハン全戦史』自然と科学社、1989年、pp. 22-28.

¹¹ 斎藤二郎『支那をめぐる日ソ英米』今日の問題社、1936年、р. 82.

¹² Мөн тэнд, р.110.

¹³ Батлан Хамгаалах Яамны баримт. 陸軍省一陸満密大日記—S11—9—41. Японы Батлан Хамгаалах Яамны архив.

1.2. Коммунизмын эсрэг түшиц газар болох Өвөр Монгол

Өвөр Монгол нь Японы коммунизмын эсрэг бодлогын өмнөх фронт болсон нь дэлхийн ээдрээтэй нөхцөл байдлаас шалтгаалсан юм. Тодруулж хэлбэл Халхын сүмийн мөргөлдөөн зэрэг хилийн маргаанаас болж сэв сууж эхэлсэн Япон, Зөвлөлтийн харилцааг “Манжуурын хэлэлцээр”-ээр шийдвэрлэхийг оролдсон хэдий ч бодит үр дүнд хүрч чадалгүй улам хурцадсаар байв. Нөгөө талаар Европ дахь нөхцөл байдал ч ялгаагүй хурцдаж 1930 оноос хойш олон хямралуудтай тулгарчээ.

1933 оны 1 сард Германд Гитлер засгийн эрхийг авч хоёр жилийн дараа 1935 оны 3 сарын 16-нд дахин цэрэг дайны бэлтгэлээ хийхээр зарлав. 1935 оны 10 сарын 3-нд Муссолинийн Итали Улс Этопи руу цэрэг оруулсан байв. 1935 онд Москвад болсон Коминтерны VII их хурал дээр Зөвлөлтийн засгийн газар Япон, Герман, Италийн фашизмын эсрэг ардын дайн өрнүүлэх шийдвэр гаргав¹⁴. Түүний дараа 1935 оны 10 сард Японы засгийн газар “Хиротагийн гурван зарчим” (Японы эсрэг хөдөлгөөнийг зогсоох, Япон, Манж, Хятад холбоолох, хамтаар коммунизмаас сэргийлэх)-г тунхаглав¹⁵. Улмаар Япон Үндэстний холбооноос гарч, цэргээ багасгах гэрээг цуцлах зэрэг ажиллагаанаас болж, гадаад харилцааны талаар ганцаардмал байдалтай байснаасаа мултрахын тулд Германтай ойртож, 11 сарын сүүлээр Төв штабын дэд хурандаа Вакамацү Тадаказү (若松只一)-г Герман руу илгээн Нацист намын Гадаад Явдлын Яамны сайд Риббентроптой уулзаж, Коммунизмын эсрэг хамтарсан гэрээ байгуулахыг санал болгожээ¹⁶.

Ингэж коммунизмын эсрэг Японы бодлого хэрэгжиж эхлэв. Үүнээс хойш “Улааны замын онол” нь Японы нийгмийн яриа хэлэлцээнд хүчтэй нөлөөлж, дээр нь газарзүйн байрлал ч давхар нөлөөлөн Өвөр Монгол нь эцэстээ Японы коммунизмын эсрэг бодлогын гол түшиц газар болов. Энэхүү “Улааны замын онол” гэдэг нь тухайн үед Коминтерны дэлхийн хувьсгал хэмээх үзэл санаа, түүний арга барилыг дэлхий дахинд дэлгэрүүлэхийн төлөөх онцгой зам хэмээн тайлбарлаж байсан ч бодитойгоор зүүн Азийг чиглэсэн зам юм¹⁷. Тухайлбал, Хаалган, Хүрээг холбосон зам, 1933 онд байгуулагдсан Сүй-Юань, Шинжааныг холбох замыг зааж аль нь ч Өвөр Монголын Улс төр, эдийн засгийн төв хэсгийг дайрч байжээ¹⁸.

Уг санаа дэлгэрч эхэлсэн нь 1925-1927 оны Хятадын хувьсгалын үе юм. Тухайн үед ЗХУ нь Владивосток болон Хятадын гадна үүд болох Шанхай, Гуандунаар дамжих зам эсвэл баруун хойдын замаар дамжин хувьсгалт тэмцлийг идэвхтэйгээр дэмжиж байснаас үүсэлтэй юм. Түүний дараа Хятадын Коммунист болон Гоминдан намын хагацал, ДИУ-ын Засгийн газраас ЗХУ-д баримталж байсан бодлогын өөрчлөлтөөс хамаарч нэг үе үнэн утгаа алдсан ч 1935 оны “Урт марш”-ны дараа улаан цэрэг буюу Хятадын Коммунист намын цэрэг баруун хойд нутаг руу шилжиж, Шанбэй (Шаньсийн хойд хэсэг)-т хувьсгалын түшиц газар болох Холбооны бүс нутгийг байгуулмагц нэг хэсэгтээ мартагдаад байсан “Улааны зам” гэдэг үг дахин шинээр сэргэжээ¹⁹. Нөгөө талаар 1930 оны 4 сард

¹⁴ Өмнө дурьдсан 『日ソ中立条約の研究』、南窓社、p. 42。

¹⁵ Өмнө дурьдсан 『日米開戦と日ソ関係』、p. 139。

¹⁶ Өмнө дурьдсан 『日ソ中立条約の研究』、p. 42。

¹⁷ 鈴木武雄「大陸ルート論」『アジア問題講座第三巻』創元社、1940年、pp. 376-377。

¹⁸ 日森虎雄「赤色ルート論」『アジア問題講座第三巻』創元社、1940年、pp. 157-158。

¹⁹ Өмнө дурдсан 「赤色ルート論」、p. 148。

Турксиба төмөр зам баригдаж, Сибирь болон Туркестан төмөр замаар холбогдсон бөгөөд түүний урт нь 2519 км-т хүрч, Шинжааныг тойрсон хэлбэртэй байв²⁰.

Түүний дараа Манжийн хэрэг үүсэж, захирагч Шэнь Шыцай нь тухайн газар нутагт очиж, Зөвлөлтийг дагасан засгийн газар байгуулагдсан байна²¹. Шинжаан дахь Зөвлөлтийн улс төр, эдийн засгийн талаарх энэхүү нөлөөлөл нь тухайн үед Шинжаан бүхэлдээ улаан болж, хоёрдогч Гадаад Монгол боллоо хэмээх ойлголтыг Японд төрүүлж, сонор сэрэмжийг нь дээшлүүлж байв²². Ялангуяа Шинжаанаар дамжин Хятадын коммунист нам Зөвлөлттэй шууд харилцаа тогтоовол Хятадын холбооны бүс нутаг томрох тул Японы хувьд хүсээд байх зүйл биш байв²³. Эцэстээ Өвөр Монголын газар нутаг нь газарзүйн хувьд дээрх нөхцөл байдлыг зогсоох боломжтой байсан тул Японы тал чухалчлан үзэх болов. Энэ тухай Японы Гадаад Хэргийн Яамны материалд байгааг сийрүүлбэл,

ЗХУ-ын коммунист үзлийг дэлгэрүүлэх ажиллагаа нь Гадаад Монгол ба Шинжаанаар дамжин Өвөр Монгол, Хятадын хойд хэсэг рүү бага багаар ойртож буй. Үүнийг хориглон зогсоохын тулд хурдхан шиг Өвөр Монголд Япон Манжид ээлтэй засгийг байгуулан бидний зүгээс идэвхтэйгээр дэмжих замаар коммунист үзлийг хориглон зогсоох нь бидний өмнө тулгамдсан үүрэг юм²⁴.

Энэ асуудлын тухай Амаоки (天沖郷廟) дараах байдлаар ярьсан байдаг.

ЗХУ нь Шинжаанаар дайран Гансүг туулан Хятадын баруун хойд нутаг зүг ойртож байна. Нөгөө талаар Монгол улсаар түшиц болгосон ЗХУ-ын хүч нь Өвөр Монголын баруун хэсгээр дайран Ниншия нутаг зүг тэлж буй. Энэ нь ЗХУ болон Хятадын хойд хэсгийг шууд холбоотой болгож байна. “Монгол-Зөвлөлтийн харилцан тусалцах протокол” нь уг бодлогодоо итгэл өвөрлөж байхын илрэл юм. Японы Хятадын хойд хэсэг дэх байр суурь маш аюултай болоод байна. Тиймээс Япон нь Алс Дорнодын тогтвортой байдлын үүднээс ЗХУ-ын нэвтрэн орж ирэхэд хандуулан коммунизмыг хориглон зогсоох улсын холбоог байгуулахгүй бол болохгүй. Үүний хариуд Улааны бүлэг нь Хятадын хойд хэсгийг баруунаас зүүн (Шинжаанаас Хятадын хойд хэсэг), хойноос өмнө (Гадаад Монголоос Хятадын хойд хэсэг) холбож тоонолжин байдалтай болоод байна. Япон Зөвлөлтийн дайнд шийдвэрлэх фронт болох газар нь зүүн хэсгийн Манжийн газар биш харин баруун хэсгийн Монгол орон юм²⁵

Дээрх бол Квантуны армийн штабын дэд дарга Итагаки Дэмчигдонров ванд бараалхахаар очихдоо бие даасан засгийн газар байгуулахыг санал болгон хэлсний дараа удалгүй Монгол цэргийн засгийн газар байгуулагдах үеийн олон улсын нөхцөл байдал болно.

²⁰ 千葉山男『極東赤化の現段階と中国共産党の動向』辺境問題研究所、1935年、p. 21。

²¹ Өмнө дурдсан『支那をめぐる日ソ英米』、p. 114。

²² Өмнө дурдсан『極東赤化の現段階と中国共産党の動向』、p. 2。

²³ Мөн тэнд. p.22.

²⁴ Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. А – 6 – 1 – 2. Гадаад Хэргийн Яамны архив

²⁵ 天沖郷廟『日ソの危機を探る』今日の問題社、1936年、p. 34。

1936 оны 11 сарын 25-нд “Япон, Германы коммунизмын эсрэг тунхаглал” байгуулагдаж, түүнд социализмын сүрдүүлгээс хамгаалахын тулд хүчээ нэгтгэнэ²⁶” гэсэн чиглэл тодорхой дурдагдаж, Зөвлөлтийн эсрэг Японы дайсагнал ил болсон байна.

Улмаар жилийн эцсээр коммунизмын эсрэг Жи Дун (Хэбэйгийн зүүн хэсэг), Жи Ча (Хэбэй Цахар)-ийн засгийн газар байгуулагдсан байв²⁷. Тухайн үед Японы тал коммунизмын эсрэг тунхаг нь олон улсын коммунизмын эсрэг, Зөвлөлтийн эсрэг бодлого биш гэж тайлбарлаж байсан ч Зөвлөлтийн Гадаад хэргийн сайд Молотов 11 сарын 29-ны ээлжит бус Зөвлөлтийн их хурал дээр “Японы дотоод асуудал нь бидэнд хамаагүй ч Япон, Германы тунхгийн тухайд дурдахгүй бол болохгүй. Тунхгийн зорилго нь коммунизмыг хориглоход биш харин Хятад, Европ, ЗХУ-ыг түрэмгийлэхэд чиглэгдэж байгаа нь олноороо мэдэж байгаа зүйл” хэмээн няцааж, тамга дарахаар тохирчлоод байсан “Загас агнуурын гэрээ”-нд тамга дарахаас татгалзан эсэргүүцлээ илэрхийлжээ. Ингээд Япон-Зөвлөлтийн харилцаа улам муудав²⁸.

Түүний дараа Хятадад Сүйюаний хэргээс эх үүсэлтэй Шианий (西安) хэрэг гарч, үрдүнд коммунист нам, Гоминдан намын хамтын ажиллагаанд тулгуурлагдсан Японыг эсэргүүцэх нэгдмэл фронт байгуулагдсан байна. ЗХУ ч Хятадын талаарх бодлогоо өөрчлөн тусламжаа идэвхжүүлж, Японы эсрэг хамтын аюулгүй байдлын тогтолцоог байгуулж, битүүмжлэх бодлогоо эрчимжүүлжээ²⁹. Түүнчлэн, Япон-Хятадын дайн эхэлсний дараа Чан Кайшигийн Японы эсрэг дайтах шийдвэрийг сайшааж, туслахаа амлан, 1937 оны 8 сарын 22-нд “Хятад-Зөвлөлтийн харилцан үл довтлох гэрээ”-г байгуулав³⁰.

Ингэж Японыг эсэргүүцэх нэгдмэл фронт байгуулагдсан, Хятад-Зөвлөлтийн гэрээ байгуулагдсан, цэргийн талаар хамтран ажиллах болсон зэрэг үйл явдлууд нь Японы талд өөрсдийг нь бүсэлж байх шиг харагдсан байна. Үүнийг ялахын тулд коммунизмын эсрэг шугамаа бэхжүүлэхээс өөр аргагүй хэмээн үзэв. Түүнээс хойш коммунизмыг хориглон зогсоох шугамын гол цэг болсон Өвөр Монгол зүг чиглүүлсэн бодлогоо улам эрчимжүүлсэн бөгөөд түүний үр дүн нь 1939 оны 9 сард байгуулагдсан Монголын холбон нийлэлдэж Өөртөө засах засгийн газар юм. Түүний засаг барих бодлогод “Коммунизмын хор нөлөөнөөс үндэстнүүдийг чөлөөлөн дэлхийн коммунизмын эсрэг фронтыг бэхжүүлнэ³¹” гэж байсан шигээр энэ засаг нь яг л Японы коммунизмын эсрэг түшиц газар байжээ.

²⁶ 外務省『日本外交文書』（第二次欧州大戦と日本 第一冊 日独伊三国同盟・日ソ中立条約）六一書房、2012年、p. 3。

²⁷ Өмнө дурдсан 「支那をめぐる日ソ英米」、p.110。

²⁸ Өмнө дурдсан 「日ソ中立条約の研究」、pp.43-44。

²⁹ Өмнө дурдсан 「日米開戦と日ソ関係」、p.143。

³⁰ Мөн тэнд. p.147。

³¹ Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. А – 1 – 1 – 0. Японы Гадаад Хэргийн Яамны архив.

2. Халх голын дайн болон Японы гадаад бодлогын өөрчлөлт

2.1. Халх голын дайны тухай

1939 оны 5 сарын 11-ээс 9 сарын 15-ны хооронд Манж Улс болон БНМАУ-ын хилийн орчим хилийн заагийн маргаанаас үүдэж, 4 сарын турш зэвсэгт мөргөлдөөн үүсжээ. Энэ нь Халх голын дайн, өмнөөс үргэлжилж ирсэн газар нутгийн маргааны хамгийн сүүлийн үе шат юм. Энэ хэргийн талаар судалгааны бүтээл олон байгаа учраас энд нарийн өгүүлэхгүй зөвхөн өмнөх судалгааны үр бүтээлд тулгуурлан энэ тухай товчхон ярья³².

Хэрэг явдлын эхлэл 5 сарын 11-нд болсон жижиг мөргөлдөөн байсан бөгөөд Манж Улс, Монгол Улс, Квантуны арми, Зөвлөлтийн үзэл баримтлал тус тусдаа өөр байсан ч аль аль тал нь нөгөө этгээдээ шүүмжлэх талаар адилхан байдаг. Тэгвэл тухайн үеийн Монголын түүхийн баримтуудад дараах байдалтай байна.

*Таван сарын 11-нд жижиг буу, хүнд, хөнгөн зэвсгээр зэвсэглэсэн цэрэг 400 хүнээс бүрдсэн Японы цэргийн хүчин Номонхан Бүрд овоо чиглэлээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын газар нутагт халдав. Японы цэргийн хүчин 8 км нэвтрэн орж, хилийн харуулын баазыг бүслэн дайрч 2 хүн нас барж, 1 хүн шархдсан байна. Дайсны давуу хүчний дайралтаас болж манай харуулын цэрэг хойш ухарч, Манж болон Японы цэрэг Монголын нутагт 20 км түрэмгийлэн оров. Гэвч харуулын баазын цэргийн нөөц хүчээр Номонхан овооны өмнөх Нүрэн овооны орчимд хашигдан 5 сарын 12-ны өдрийн орой болтол хилээс гадагш гартлаа ухарсан байна*³³.

Халх голын дайны талаарх судалгаагаараа алдартай Үшижима Ясүчика (牛島康允)-ийн үзсэнээр, тэр өдрийн тулаан нь өмнө тасралтгүй гарч байсан мөргөлдөөнтэй хэмжээ болон шинж чанарын хувьд онцгой зөрөө байгаагүй. Гэнэт болсон явдал ч биш, үргэлж болж байсан мөргөлдөөний ганцхан л төдий байсан гэдэг. Тэгвэл, яагаад том хэмжээний дайн болж өргөжсөн бэ? Тэрээр өмнөх хэргүүдээс өөр гэж дурдсан нь Японы гаргасан хөтөлбөрийн өөрчлөлт байв³⁴.

Энэ нь алдарт “Манж-Зөвлөлтийн хилийн мөргөлдөөнийг шийдвэрлэх хөтөлбөр” байж, үүнийг хэрэг гарахаас өмнөхөн 1939 оны 4 сарын 25-нд Квантуны армийн Ерөнхий командлагч Үэда Кэнкичи (植田謙吉)-ийн дайн зарлах тушаалын ёсоор уламжилсан байв. Үүнд, “Дайрахгүй, дайруулахгүй байх нь Манж Улсын батлан хамгаалахын үндэс” гэж үзсэн бөгөөд “Зөвлөлтийн цэрэг (Гадаад Монголын цэргийг багтаана) хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд сайтар бэлтгэсний дараа туйлбартай цээрлэл үзүүлнэ” гэжээ³⁵.

Жижиг мөргөлдөөн эхэлснээс хойш хоёр хоногийн дараа буюу 13-ны өдөр тухайн мэдээлэл Манж Улсын армиас Хайларын 23-р дивизийн удирдах багт ирсэн үед Квантуны армийн дайны тушаалыг аваад ажилдаа эргэн ороод байсан Комацубара (小松原) дивизийн дарга дивизийн хурлыг нээж бүх цэргүүдэд энэ

³² 三浦信行ほか「日露の資料で読み解く「ノモンハン事件」の一側面」『アジア・日本研究センター紀要』(5)、2010年、pp. 73-95。

³³ Өмнө дурдсан『ノモンハン全戦史』、p. 38。

³⁴ Мөн тэнд, p.37.

³⁵ 辻政信『モンハン秘史』毎日ワンス、2009年、p. 70。

тушаалыг дамжуулж байсан гэдэг. Тэрээр даруй явган цэргийн 16-р батальон болон хайгуулын багт ажлын даалгавар өгөхийн сацуу Хайларт байсан Манж Улсын армийн морьт ангийг хамтад нь тухайн газар руу явуулжээ. Мөн даалгаврын тухай Квантуны армийн удирдагчид мэдүүлэхийн хамт хэрэг томроход бэлтгэн 100 машинтай анги болон Хайларт байсан агаарын хүчнийг дивизийн удирдагчийн удирдлага доор орохыг тушаасан байв³⁶.

5 сарын 21-нд Гадаад Хэргийн Яамны сайд Молотов, ЗХУ-д суух Японы элчин сайд Того Шигэнори (東郷茂徳)-г Кремльд дуудаж, Номонханд болсон Япон-Манж цэргийн түрэмгий ажиллагааг Зөвлөлтийн засгийн газар Монгол Улсын засгийн газартай байгуулсан харилцан туслалцах протоколд үндэслэн хүчтэй эсэргүүцэж байгаагаа илэрхийлж, эсэргүүцлийн бичгээ Тогод гардуулжээ³⁷. Гэвч Японы засгийн газрын бодлого нь “Асуудлыг Манж-Монголын хоорондын асуудлаар шийдвэрлэж, уг асуудлыг томруулахгүй байх. Энэ хэрэг дээр Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах протоколыг хүлээн зөвшөөрчихвөл үнэн хэрэг дээрээ Зөвлөлтийн гадаад Монгол дахь эрх мэдлийг зөвшөөрсөн үр дүнд хүрэх учраас үүнээс зайлсхийх явдал” байжээ³⁸. Тиймээс 25-нд Тогогоос өгсөн хариулт нь “Японы засгийн газар Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах протоколыг хүлээн зөвшөөрөөгүй учраас Гадаад Монголын асуудлаар танай улсын эсэргүүцлийг хүлээн авах боломжгүй. Энэ удаагийн асуудал нь гадаад Монголын цэргийн хууль бус хил нэвтэрснээс болж үүссэн асуудал учраас Манж Улс нь нэгэнтээ Монгол Улсын засгийн газарт эсэргүүцлээ илэрхийлсэн. Хэрэв танай улс энэ хэрэгт холбогдож байвал Японы засгийн газар нь Япон, Манж Улсын хамтран батлан хамгаалах үзлийн үүднээс түүнийг зогсоохыг хатуу шаардаж байна хэмээн огтхон ч найр тавих шинжгүй байжээ³⁹. Тогогийн энэхүү хариулт нь Сталиныг хүчтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн байна. Түүний тушаалаар Белоруссын цэргийн тойргийн командлагчийн орлогч, дэслэгч генерал Жуковыг Номонхан руу илгээхийг шийдсэн нь энэ өдрийн учир юм.

6 сарын 01-нд Жуков нь Минскийн 3 дугаар морьт цэргийн удирдах багт бэлтгэл сургуулилтын талаар ажиллаж байхдаа батлан хамгаалах ардын зөвлөл рүү очихыг шаардсан тушаалыг хүлээж авчээ. Дараагийн өдөр нь Москвагийн Батлан хамгаалах ардын зөвлөлөөс “Яаравчлан тухайн газар яв” гэсэн тушаалыг авсан тэрээр бэлтгэлээ дуусгамагц 6 сарын 05-ны өглөө Монголын Тамсаг булагт хүрч ирсэн байна⁴⁰. Тэрээр даруйхан нөхцөл байдалтай танилцан байдлыг ойлгосны дараа Батлан хамгаалах ардын зөвлөлд агаарын нэмэлт хүч, явган цэргийн 3 дивиз, танкийн 1 дивиз болон их бууны нэмэлт хүч авахыг шаардаж, зөвшөөрөл авсан байна. 7 сард мэргэн буучийн 3 дивиз, танкийн 2 батальон, хуягт машины гурван батальон, агаарын 1 батальоны бүрэлдэхүүнтэйгээр нэгдүгээр цэргийн хороо бүрдэж, тэрээр өөрөө удирдсан байв⁴¹.

8 сараас Монгол-Зөвлөлтийн цэрэг том дайралтаа эхлүүлж, Квантуны арми маш ноцтой хохирол амсав. Квантун арми Хятадын байлдааны талбараас нэмэлт

³⁶ 森山康平『はじめてのノモンハン事件』PHP研究所、2012年、p. 72。

³⁷ 半藤一利『ノモンハンの夏』文芸春秋、2001、p. 107。

³⁸ Өмнө дурдсан『日ソ中立条約の研究』、p. 56。

³⁹ Өмнө дурдсан『ノモンハンの夏』、p. 150。

⁴⁰ 中山正夫『ソ連側資料からみたノモンハン事件』防衛研修所、1978年、p. 46。

⁴¹ Өмнө дурдсан『ノモンハン事件』、p. 76。

хүч татан 9 сарын 10-ны үед Зөвлөлт-Монголын цэргийн эсрэг довтлохоор төлөвлөж байсан ч⁴², 8 сарын 23-нд ЗХУ-Германы хооронд “Харилцан үл довтлох гэрээ” байгуулагдаж Европын байдал санаснаас өөрөөр эргэснээс болж, түүнийгээ хэрэгжүүлж чадаагүй. Ингээд дайн дуусах зүгтээ хандсан байна

Дашрамд энд Молотов-Риббентропын “Харилцан үл довтлох гэрээ” нь хэрхэн Халх голын дайнд нөлөөлсөн гэдгийг товчхон өгүүлбэ. ЗХУ-Германы хэлэлцээр сүүлчийн шатандаа ороод байсан үеэр ЗХУ-ын Гадаад Явдлын яамныхан Германы засгийн газарт хандан Халх голын асуудлын талаар зохицуулж өгөхийг тасралтгүй шаардаж байв. Үүгээр барахгүй ЗХУ-ын талынхан энэхүү асуудлыг хэлэлцээрийнхээ хамгийн тэргүүн байранд тавьж байв. Жишээлбэл, тухайн үед Германы Москвад суугаа элчин сайд Берлиний засгийн газартаа явуулсан мэдээндээ “Халх голын асуудал нь хамгийн чухал асуудал болоод байгаа юм шиг байна. Молотов биднээс Японы түрэмгийллийг зогоолгож өгөхийг шаардаж байна.” гэсэн байв. Хэдэн өдрийн дараа тэрээр дахин Молотовтой уулзахад нь Молотов уг асуудлыг дахин дурдаж Япон Зөвлөлтийн харилцааг сайжруулах тал дээр Герман нь өөрийн нөлөөгөө үзүүлэхийг шаардсан байв. Мөн тус гэрээг байгуулагдахын урьд шөнө болсон хэлэлцээр дээр ч энэхүү асуудлыг тухайн үед ярилцсан долоон асуудлынхаа хамгийн эхний асуудал болгосон байдаг⁴³. Гэвч эдгээр асуудлын талаар олон өгүүлэл зохиол байх учраас энд нарийн ярихгүй⁴⁴.

8 сарын 28-нд Хиранүма (平沼)-ийн засгийн газар “Европын нөхцөл байдал тун будилаантай байна” хэмээн Ерөнхий сайдын суудлаасаа огцорч 30-ны өдөр Абэ (阿部)-ийн засгийн газар байгуулагдсан байна. 9 сарын 01-нд Герман, Польш руу цэрэг оруулж, 03-ны өдөр Англи, Франц нь Германы эсрэг дайн зарласнаар Дэлхийн II дайн эхлэв.

Абэгийн шинэ засгийн газрын гадаад бодлогын цөм нь Хятадын асуудлыг шийдвэрлэх байсан бөгөөд нөгөө талаар ЗХУ-тай харилцаагаа сайжруулах тал дээр ч идэвхтэй байв. 9 сарын 04-нд Японы засгийн газар ЗХУ-д суух элчин сайд Тогод хандаж хоёр улсын харилцааг бүх талаар зохицуулах үүднээс хэлэлцээр хийхийг зааварлах зэргээр Халх голын дайны асуудлыг хамтад нь шийдвэрлэхийг тушаажээ⁴⁵.

9 сарын 09-нөөс Кремльд элчин сайд Того, Гадаад хэргийн яамны сайд Молотовын хооронд дайныг зогсоох хэлэлцээр эхлэв. Энэ хооронд дайн үргэлжилсээр байв. 9 сарын 15-нд Японы хамгийн сүүлийн бөмбөгдөлт Тамсагт болсон байна. Түүний дараахан Москвад дайныг зогсоох гэрээ байгуулагдаж, 16-ны өдрийн 2 цагт цэрэг дайны бүхий л үйл ажиллагааг зогсоов⁴⁶. Халх голын дайны төгсгөл энэ буюу.

⁴² Өмнө дурдсан 「露の史料で読み解く「ノモンハン事件」の一側面」、p. 78.

⁴³ Stuart D. Goldman., The Influence of Khalkhin Gol on the Outbreak, Conduct, and Outcome of World War II. 今西淳子, ボルジギン・フスレ編 『ノモンハン事件70周年—バートル国際シンポジウム報告論文書』 風響社、2009年、p. 77.

⁴⁴ Жишээлбэл, Stuart D. Goldman, Nomonhan, 1939: The Red Army's Victory That Shaped World War II, Naval Institute Press, 2013; Р.Болд, Зарлаагүй дайн: Халхын голын байлдааны цэрэг-дипломатын түүх, Непко хэвлэлийн газар, УБ, 2014. мэт судалгааны зүйл буй.

⁴⁵ Өмнө дурдсан 『日ソ中立条約の研究』、pp. 57-58.

⁴⁶ Өмнө дурдсан 『はじめてのノモンハン事件』、p. 308.

2.2. ЗХУ-тай харилцаагаа сайжруулах гэсэн Японы оролдлого

Халх голын дайны дараа Японы дэлхийн стратегид том өөрчлөлт орж “Умард зүг дайлах бодлого”-оос “Өмнө зүг дайлах бодлого”-д шилжив. Гэвч Англи, Америкийг дайснаа болгож, Номхон далай болон Зүүн өмнөд Ази зүг гарахад хойноос ЗХУ-ын нуугдмал аюулыг багасгах шаардлагатай байв⁴⁷. Иймэрхүү ойлголт дээр тулгуурлан гарч ирсэн нь ЗХУ-тай харьцаагаа сайжруулах явдал байсан бөгөөд энэ нь ЗХУ-ын Хятадад өгч байгаа дэмжлэгийг зогсоож, улмаар Япон-Хятадын дайны төгсгөлийг авч ирнэ хэмээн төсөөлөгдөж байв. Үүнээс хойш Японы төр засаг болон цэргийн удирдагчид өнгөрсөн үед Зөвлөлтийн талаас хааяа санал болгож байсан “Харилцан үл довтлох гэрээ” эсвэл “Төвийг сахих гэрээ”-ний тухай идэвхтэйгээр хандах болов.

Нөгөө талаар Зөвлөлтийн тал ч 1939 оны өвлөөс эхэлсэн Зөвлөлт-Финляндын дайнаас болж олон улсын тавцанд ганцаардаж байсан тул Японтой харилцаагаа сайжруулахад дуртай байв. Түүнийг ойлгосон Японы Гадаад Хэргийн Яам Зөвлөлттэй харилцаагаа зохицуулах хэлэлцээрээ идэвхжүүлж, 1940 оны 4 сарын 22-нд коммунизмын эсрэг бодлого баримтална гэх урьдал нөхцөлтэйгөөр Япон-Зөвлөлтийн харилцан үл довтлох гэрээг байгуулахыг бодолцоно гэсэн агуулга бүхий “Хоёр дахь удаагийн гадаад бодлогын хөтөлбөр”-ийг боловсруулсан байдаг.

Цэргийн дотоодод ч мөн адил хандлага харагдаж байв. Төв штабын мэдээллийн хэлтсийн дарга хошууч генерал Цүчихаши Юүицү (土橋勇逸) Япон-Хятадын дайныг шийдвэрлэх аргын хувиар, ялангуяа Чунциний засгийн газрыг эдийн засгийн талаар хавчих бодлогын үүднээс Зөвлөлтөд ойртох төлөвлөгөөг боловсруулж, шинэ гадаад бодлогоо 4 сарын эхээр Төв штабын хэлтсийн даргын хуралд өргөн барьж зөвшөөрүүлжээ⁴⁸.

1940 оны 6 сарын 01-нд ЗХУ-д суугаа элчин сайд Того Шигэнори болон Молотовын хооронд Манж, Монголын хилийн асуудлаар уулзалт явагдаж хоёр улсын асуудлыг түргэвчлэн шийдэх ёстой гэдэг дээр санал нэгджээ⁴⁹. 7 сарын 02-нд Того, Молотовт Япон-Зөвлөлтийн энх тайван найрамдлыг бэхжүүлж тус тусынхаа газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх ёстой гэж хэлжээ. Түүний зэрэгцээ элчин сайдаас, “Зөвлөлт-Японы төвийг сахих гэрээ”-ний төслийг өргөн барив⁵⁰. Уг гэрээний нэгдүгээр зүйлд, “Гэрээ тогтоох хоёр улс нь 1925 оны ЗХУ-Япон Улсын хоорондох үндсэн гэрээ нь хоёр улсын харилцааны үндэс болно гэдгийг зөвшөөрнө. Гэрээг байгуулах хоёр улс нь энх тайван ба нөхөрсөг харилцаагаа үргэлжлүүлж харилцан нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзнэ” гэж заасан байна⁵¹. Молотов үүнийг зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн ч залгаад Япон, Зөвлөлтийн улс төрийн эвсэл нь Америк, Зөвлөлт болон Хятад, Зөвлөлтийн харилцааг муутгасан бөгөөд Зөвлөлтөд ямар ч үр ашиггүй. Харин Хятад, Японы асуудлыг шийдвэрлэхийг урагшлуулж улмаар өмнө зүг идэвхтэй хөдлөх боломжийг олгох учраас Японд их ашигтай байх нь тодорхой. Тиймээс зохих хэмжээний хариуг шаардахгүй бол болохгүй гэж хэлсэн байна⁵².

⁴⁷ ボリス・スラブィンスキ 『日ソ中立条約—公開されたロシア外務省機密文書』岩波書店、1996年、p. 59.

⁴⁸ Өмнө дурдсан 『日ソ中立条約の研究』、pp.61-67.

⁴⁹ Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. В-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив. Өмнө дурдсан 『日ソ中立条約—公開されたロシア外務省機密文書』、p.59.

⁵¹ Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. В-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив.

⁵² 堀内謙介 『日本外交史21』（日独伊同盟・日ソ中立条約）鹿島平和研究所、1971年、p. 267.

Зөвлөлт, Японы эвсэл нь хоёр улсын үл ойлголцох байдлыг үгүй болгож дэлхийн шинэ дэглэмийг байгуулах тэмцэлдээ үйлчлүүлэхийг хүсэж байсан Германд таалагдсан байна. 1940 оны 7 сарын 04-нд Германд суугаа Японы элчин сайд Күрүсү Сабүроү (来栖三郎)-аас Арита (有田) Гадаад хэргийн сайдад илгээсэн цахилгаан мэдээндээ Германы тал нь Япон, Зөвлөлтийн харилцааг сайжрахыг хүсэж байна гэдгийг дамжуулсан байна⁵³. Үүнээс хойш Япон нь Германтай харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ Зөвлөлт, Японы хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, Английн эсрэг холбоог байгуулахыг дахин давтан шаардсан байна. Ингээд гарч ирсэн нь “Япон, Герман, Итали, Зөвлөлтийн холбооны онол” юм. Японы гадаад бодлого нь энэ мэтээр коммунизмын эсрэг үзлээс Английн эсрэг үзэл болж хувирсан нь яриангүй Москвад таалагдсан байна. Гэхдээ нөгөө талаар бас Америк Японы харилцаан дээр хүйтэн ус цацсан явдал байв.

1940 оны 7 сарын 27-нд Мацүокагийн удирдлага дор Коноэ (近衛)-ийн хоёр дахь Засгийн газар “Дэлхийн нөхцөл байдлын шилжилтийг дагасан цаг үеийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр” -ийг боловсруулж, баталсан бөгөөд түүндээ “Эзэнт гүрэн нь дэлхийн байдлын хувиралт өөрчлөлтийг зохицуулж, дотоод гадаадын байдлыг сайжруулахын хамт үтэр түргэн Хятадын болон өмнөдийн асуудлыг шийдвэрлэнэ” гэжээ. Түүнээс гадна бас “Герман, Италитай Улс төрийн эв нэгдлээ бэхжүүлэн, ЗХУ-тай дипломат харилцааг сайжруулахын хамт өмнө зүгт болж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд зэвсэг хэрэглэж болно” гэж заасан байна⁵⁴. Энэ мэтээр өмнө зүгийн асуудлыг шийдвэрлэх төсөл, өөрөөр хэлбэл “Өмнө зүг дайлах бодлого” бодит байдал дээр хэрэгжихийн зэрэгцээ ЗХУ-тай төвийг сахисан гэрээ байгуулах нь Японы дипломат харилцааны нэн тэргүүний ажил болжээ.

8 сарын 05-нд Гадаад хэргийн сайд Мацүока-ийн тушаалаар Того Молотовт бараалхан, шинэ засгийн газар нь төвийг сахих гэрээг аль болох түргэн байгуулахыг хүсэж байна гэдгээ илэрхийлж, 7 сарын 02-ны төслийн Зөвлөлтийн талын хариултыг авахыг хүсжээ. 8 сарын 14-нд Молотов, Тогог дуудаж, Төвийг сахих гэрээний талаар Японы талын тавьсан саналын хариуг бичгээр өгсөн байна. Түүндээ Японы Төвийг сахих гэрээ байгуулах саналыг Зөвлөлтийн засгийн газар зөвшөөрч байна гэдэг саналыг илэрхийлсэн ч жинхэнээр гэрээ байгуулах үед Японы ашиг сонирхлоос гадна Зөвлөлтийн ашиг сонирхлыг ч тусгах ёстой гэдэг саналыг дурдсан байна. Улмаар нэгдүгээр зүйлд, Подсдамын гэрээ хүчин төгөлдөр байгаа 1925 оны Бээжингийн гэрээ (Зөвлөлт- Японы үндсэн гэрээ)-г хоёр улс харилцааныхаа үндэс болгох ёстой гэх заалт нь одоогийн нөхцөл байдалд нийцэхгүй. Ялангуяа Япон нь 500 мянган хүнээс илүү цэргийг Манжид оруулснаас болж, Хятадын бүрэн эрхийг зөрчин Подсдамын гэрээг ч зөрчиж байгаад өөр хэлэх үггүй хэмээн эсэргүүцсэн байна⁵⁵. Түүний хариуд Тогогийн үйлдэл нь “хоёр улсын харьцаагаа сайжруулах гэж байгаа тухайн үед гэнэт Подсдамын гэрээг гаргаж ирээд энэ тэр ярих нь үнэхээр ойлгогдохгүй асуудал байна. ЗХУ нь Манж-Оросоос чухам юуг хүсээд байгаа бол” гэсэн байдалтай байв⁵⁶.

⁵³ 外務省『日本外交文書』（第二次欧州大戦と日本 第一冊 日独伊三国同盟・日ソ中立条約）六一書房、2012年、p. 173。

⁵⁴ Хуурай Газрын Цэргийн Яамны баримт. 中央一戦争指導重要国策文書—1088. Японы Батлан Хамгаалах Яамны архив.

⁵⁵ Өмнө дурдсан『日ソ中立条約—公開されたロシア外務省機密文書』、p. 61。

⁵⁶ Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. В-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив.

Түүний дараа Мацүокагийн хийсэн албан тушаалын өөрчлөлтөөр 8 сарын 29-нд Того элчин сайдаасаа бууж оронд нь Татэкава Ёошицэгү (建川美次) Хуурай газрын цэргийн дэслэгч генерал Зөвлөлтөд суух элчин сайд болсон байна. Шинэ сайдыг ажлаа эхлэхэд Молотовын хамгийн эхний үг нь “Герман Польшын талыг өглөө. Японы саналыг Зөвлөлт зөвшөөрвөл түүний хариуд юу өгөх вэ?” гэсэн газар нутгийг авах зорилготой шаардлага байжээ⁵⁷.

3. “Зөвлөлт-Японы төвийг сахих гэрээ” болон Өвөр монголын асуудал

3.1. “Япон, Зөвлөлтийн харилцааг зохицуулах төсөл” болон Өвөр Монголын асуудал

1940 оны 9 сарын 27-нд Япон, Герман, Италийн хооронд “Гурван улсын эвслийн гэрээ” байгуулагдав. Түүнд Ази болон Европын газар нутаг дахь шинэ дэг журмыг байгуулахыг илэрхийлж байсан ч⁵⁸, нөгөө талаар “Герман – Зөвлөлтийн харилцан үл довтлох гэрээ”-ээс болсон тус хоёр улсын нөхөрсөг харилцааг Япон, Зөвлөлтийн харилцаа хүртэл өргөжүүлж, улмаар Япон Зөвлөлтийн гадаад харилцааг зохицуулж, боломжтой бол Япон, Герман, Зөвлөлтийн холбоо болж, үүгээрээ Англи, Америкийн эсрэг Японы байр суурийг бэхжүүлж, Хятадын асуудлыг шийдвэрлэхэд ашиглана” гэсэн нууц санаа бас байжээ⁵⁹.

Гурван улсын эвсэл байгуулагдсаны дараа Японы Гадаад Хэргийн Яам нь түргэвчлэн Зөвлөлттэй гэрээ байгуулах нөхцөлийн тухай “Япон-Зөвлөлтийн харилцааг зохицуулах төсөл”-ийн зохиох ажилд оров. Тус төслийн онцлог нь төвийг сахих гэрээг байгуулахаа больж, Зөвлөлт Японы хооронд “Герман Зөвлөлтийн харилцан үл довтлох гэрээ” шиг гэрээг байгуулж, цаашид Япон, Зөвлөлт хоёр улсын нөлөөний хүрээг тогтоох тухай зүйл байв⁶⁰. Олон удаа зассаны эцэст гарсан бичиг нь 1940 оны 10 сарын 04-ний “Япон-Зөвлөлтийн харилцааг зохицуулах төсөл (анхны ноорог)” байсан бөгөөд түүний 5 дугаар зүйлд нь Зөвлөлт, Японы хоорондын харилцан ойлголцлын тухай дараах байдлаар бичжээ.

1. Зөвлөлт нь Өвөр Монгол болон Хойд Хятадын 3 муж дахь Японы уламжлалт сонирхлыг зөвшөөрч, Япон Гадаад Монгол болон Шинжаан дах Зөвлөлтийн уламжлалт сонирхлыг зөвшөөрнө.

2. Зөвлөлт нь Японы ирээдүйд их Зүүн Азийн хамтаар цэцэглэн хөгжих хүрээний өмнө зүг түрэн орохыг хүлээн зөвшөөрч, Япон нь Зөвлөлтийн төв Азийн зүг түрэн орохыг хүлээн зөвшөөрнө⁶¹.

Мацүока голлон бичсэн уг төсөлд, “уламжлалт сонирхол” гэсэн үгийг хэрэглэн Японы үзлийг дурдаж байна. Тэгвэл тэрхүү “уламжлал” гэдэг нь үнэхээр бичигдсэнийхээ дагуу байсан болов уу? Орос-Японы дайн, ялангуяа Подсдамын гэрээний дараа Япон, Оросын хооронд байгуулагдсан хэд хэдэн нууц гэрээнүүдэд нөлөөний хүрээний асуудлын талаар хэрхэн яаж дурдагдсан тухай авч үзье.

⁵⁷ Өмнө дурдсан 『日ソ中立条約の研究』、p. 75。

⁵⁸ Өмнө дурдсан 『日本外交文書』、p. 250。

⁵⁹ Өмнө дурдсан 『日本外交史21』、p. 263。

⁶⁰ Өмнө дурдсан 『日ソ中立条約の研究』、p. 79。

⁶¹ Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. А – 1 – 0 – 0. Японы Гадаад Хэргийн Яамны архив.

1907 оны 7 сарын 30-нд батлагдсан Япон – Оросын анхны нууц гэрээнд “Орос Улс нь Япон болон Солонгосын хоорондох эрх ашгийн харьцааг хүлээн зөвшөөрч, энэхүү эрх ашигт саад болох буюу гар дүрэх ажиллагааг хийхгүй” (2-р зүйл), “Японы эзэнт гүрэн нь Гадаад Монгол дахь Оросын онц эрх ашгийг хүлээн зөвшөөрч, тус эрх ашигт ямар нэгэн хэлбэрээр хохирол учруулах буюу гар дүрэх ажиллагааг хийхгүй (3-р зүйл)⁶²” хэмээн тогтож Япон, Орос хоёр улс нь Солонгос болон Гадаад Монгол дахь өөр өөрийн эрх ашгаа баталгаажуулж байсан нь харагдана.

Нөгөө талаар мөн Манжийн нутаг дэвсгэрийг ч өмнө, хойно хоёр хэсэг болгон хувааж, “Өмнөд манж”-ийг “Японы онцгой эрх ашиг”-ийн орон “Хойд Манж”-ийг “Оросын онцгой эрх ашгийн орон” хэмээн тогтоож хоёр орон ч тус тусдаа Япон Оросын нөлөөний хүрээ болсон байдаг⁶³. Гэхдээ энэ хоёр орны хоорондын заагийн талаар тодорхой заалт байдаггүй байсан учраас тодорхой болгох шаардлагатай байв⁶⁴. Энэхүү шаардлагаас болж 1910 оны 7 сарын 04-ний өдөр Япон, Оросын хооронд хоёр дахь удаагийн нууц гэрээ байгуулагдсан бөгөөд түүнд дараах байдлаар тэмдэглэжээ.

Нэгдүгээр зүйл: Япон болон Оросын засгийн газар нь 1907 оны нууц гэрээний нэмэлт заалтад буй хилийн шугамаар Манж дахь хоёр улсын онцгой эрх ашгийн газрыг тогтоохыг хүлээн зөвшөөрнө.

Хоёрдугаар зүйл: Хоёр улс нь дээрх бүс нутаг дахь онцгой эрх ашгаа харилцан хүндэтгэнэ⁶⁵.

Энд гарч буй хилийн шугам гэдэг нь “Орос, Солонгосын хилийн баруун хойд хэсгээс эхлэн Хүнчүний хойгуур гарч Туурын гол болон Гринвичийн зүүн уртрагийн 122 градусын шугамыг огтлолцсон цэг хүртэлх шугамыг зааж буй⁶⁶.

Энэ мэтээр Япон нь Солонгос болон өмнөд Манжуурыг өөрийн нөлөөний хүрээгээ болгож чадсан байна. Нөгөө талаар хойд Манжуурыг Оросын нөлөөний хүрээ гэж зөвшөөрснөөс хойш хойд Манжуур зүг дахин хүчээ тэлэх нь боломжгүй болсон байв. Яагаад гэвэл энэ нь гэрээг зөрчих учраас байлаа. Гэвч өмнөд Манжуурын баруун хэсэгт орших Өвөр Монголын тухайд хилийн шугам нь тодорхой бус байсан тул өнөөг хүртэлх шиг гадаад бодлогын арга барил дээр тулгуурлан газар нутгаа тэлэх боломж үлдээд байсан⁶⁷ бөгөөд энэ нь 1911 онд Гадаад Монгол тусгаар тогтнолоо зарласны дараа боломжтой болж, эцэстээ 1912 оны 7 сард Япон, Оросын гурав дахь нууц гэрээ батлагдсан байна. Уг гэрээний хоёрдугаар зүйлд дараах байдлаар тусгагджээ.

Өвөр Монголыг Бээжингийн уртрагаар (Гринвичийн зүүн уртрагийн 116 градус 27 минут) зүүн баруун хоёр хувааж, Япон Улс нь тухайн уртрагаас баруун тийш орших Өвөр Монголын нутаг дээрх Оросын онцгой эрх ашгийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ. Орос Улс нь тухайн уртрагаас зүүн тийш орших Өвөр Монголын нутаг дээрх Японы онцгой эрх ашгийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ⁶⁸.

⁶² 外務省『日本外交年表並主要文書（上）』、原書房、1965年、p. 280。

⁶³ Мөн тэнд.

⁶⁴ 中見立夫『「満蒙問題」の歴史的構図』、東京大学出版会、2013年、p. 36。

⁶⁵ Дээр дурдсан『日本外交年表並主要文書（上）』、p. 336。

⁶⁶ Мөн тэнд. p.281.

⁶⁷ Өмнө дурдсан『「満蒙問題」の歴史的構図』、p. 36。

⁶⁸ Өмнө дурдсан『日本外交年表並主要文書（上）』、p. 369。

Дээрх нууц гэрээнүүдийн агуулгаас харвал, тухайн үеийн Орос, Японы хооронд хүчний тэмцэлд Солонгос, Өмнөд Манж, Өвөр Монголын зүүн хэсэг болон Гадаад Монгол, Хойд Манж, Өвөр Монголын баруун хэсэг гэсэн 6 бүс нутаг байсан бөгөөд үүний өмнөх 3 бүс нутаг нь Японы нөлөөний хүрээнд, дараагийн 3 бүс нутаг нь Оросын нөлөөний хүрээнд тус тус багтаж байна. Япон, Зөвлөлт (Орос)-ын хэлэлцээрийн түүхээс үзвэл энэ нь нэг зүйлийн уламжлал гэж хэлж болно. Гэхдээ, “Япон, Зөвлөлтийн харилцааг зохицуулах төсөл”-д Өвөр Монголын баруун хэсэг нь Японы нөлөөний хүрээнд багтаж байв. Тухайн үед Япон нь хэдийн Солонгосыг нэгтгээд дээр нь бас Хойд манжийн орныг нутаг дэвсгэрийнхээ нэг хэсэг болгосон Манж Улсыг байгуулан өөрийн мэдэлдээ оруулаад байснаас үзвэл дээрх зургаан бүс нутгийн тав нь Японы нөлөөнд байсан гэж хэлж болохоор байна.

Энэ нь Зөвлөлтийн зүгээс үзвэл аль хэдийн уламжлалаасаа салсан явдал байсан учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй зүйл байжээ. Тиймээс Молотов анхнаасаа Потсдамын гэрээний үеэс уламжилж ирсэн Япон, Оросын Манжуур дахь уламжлал нь Японы хойд Манжийг эзэлснээс болж зөрчигдөж байна гэж эсэргүүцсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Япон, Зөвлөлтийн “уламжлал”-ын талаарх тайлбар нь тэс өөр байжээ. Японы төсөлд, Шинжааныг Зөвлөлтийн нөлөөний хүрээ болгоно гэж бичиж байсан ч Шинжааны асуудал нь Япон, Зөвлөлтийн хоорондох асуудал гэхээс илүүтэйгээр Хятад, Зөвлөлт цаашилбал Английг хамарсан арай өөр асуудал байв.

3.2. “Япон-ЗХУ-ын төвийг сахих гэрээ” байгуулагдсан нь

1940 оны 10 сарын 13-ны өдөр Германы Гадаад хэргийн сайд Риббентроп Сталинд урт захиа илгээж, Молотовыг Берлинд айлчлан ирүүлэхийг шаардсан бөгөөд дараа сар нь Молотов Берлинд айлчилж, 12-ны өдрөөс 13-ны өдрийн хооронд дөрвөн удаа хэлэлцээр хийсэн байдаг. 12-ны өдрийн өглөөний эхний уулзалтаар Риббентроп, “Дөрвөн Улсын хэлэлцээрийн төсөл”-ийн талаар ерөнхий тайлбарыг хийж, хариуд нь Молотов “Өмнөх нөлөөний хүрээний ойлголт нь сүүлийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан үр ашиг, утга учиргүйгээр дууссан⁶⁹” гэдгийг онцлоод нөлөөний хүрээний бодит байдалд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлжээ.

12-ны өдрийн үдээс хойшоос 13-ны өдрийн үдээс өмнө хооронд хоёр, гуравдугаар удаагийн хэлэлцээр болсон бөгөөд уулзалтад Гитлер оролцон, Молотовтой Балканы хойг болон Финландын асуудлаар ширүүн яриа өрнүүлсэн байдаг⁷⁰. Уулзалтын ерөнхий байдлыг хэлбэл, Молотов “Зүүн Азийн бүс нутгийн хил хязгаарыг тодорхой болгохын тулд юуны өмнө нарийн тодорхойлолт гаргахгүй бол болохгүй. Их гүрний хувьд ЗХУ нь Европ болон Азийн чухал асуудлуудад анхаарал хандуулахгүй байхын аргагүй⁷¹” хэмээсэн нь ЗХУ нь нөлөөний хүрээний талаар ихээхэн сонирхож байсныг илтгэнэ.

Энэ нь Германы талын цаашдын байр суурьт нөлөө үзүүлсэн эсэхийг хэлж мэдэхгүй ч 13-ны өдрийн орой Германы Гадаад хэргийн сайдын хамгаалалтын байранд болсон сүүлийн уулзалтад тус улсын Гадаад хэргийн сайд “Дөрвөн улсын хэлэлцээр”-ийн анхны төсөл гэж хэлж болох “Риббентропын төлөвлөгөө”-

⁶⁹ 『大戦の秘録—独外務省の機密文書より』(邦訳)読売新聞社、1948年、pp. 289–294.

⁷⁰ Мөн тэнд. р.315.

⁷¹ Мөн тэнд. р.321.

ний агуулгыг Молотовт танилцуулжээ. Тэрээр дөрвөн улсын газар нутгийн хүсэл сонирхлын талаар нууц гэрээ байгуулахыг санал болгож, нөлөөний хүрээ болгон Герман Улс нь Африкийг, Итали Улс нь Африкийн хойд болон зүүн хойд нутгийг, ЗХУ нь Энэтхэгийн далай руу чиглэсэн өөрийн газар нутгийн өмнөх нутгийг авахаар тус тус тогтож байсан ч, харин Япон Улсын хувьд “Дипломат хэлэлцээрийн замаар тодорхой болгох шаардлагатай” хэмээн урьдал нөхцөл тавьсны дараа “Японы арлууд болон “Манж Улс”-ын өмнөд хэсэгт шугам татсанаар хялбархан хилийг тогтоож болно” гэж нэмсэн байна⁷².

Энд анхаарал татаж байгаа зүйл гэвэл, “Японы нөлөөний хүрээг “Манж Улсын өмнөд” хэсгээр шугам татах гэж тогтоосон явдал юм. Энэ нь “Манжийн хойд хэсэг”-ийг нутаг дэвсгэрийнхээ нэг хэсэг болгосон “Манж Улс” дахь Японы байр суурийг үгүйсгэх агуулгатай байна. Гэхдээ уулзалтын өмнө буюу 11 сарын 10-ны өдөр Мацүока элчин сайд Күрүсү-ээр дамжуулан Германы талд хандан, Япон Зөвлөлтийн хооронд “Харилцан үл довтлох гэрээ” байгуулахад нь туслахыг хүссэний хариуд Риббентроп нь Японы талд санал болгосон зүйлд дээрх агуулга байгаагүй харин “ирээдүйд Японд Номхон далайн өмнөд хэсгийг” гэж бичиж байжээ. Түүгээр зогсохгүй Мацүокагийн дараа нь гаргасан “Герман, Итали, ЗХУ-тай хийх хэлэлцээрийн төсөл”-д үүнийг ЗХУ-аар хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл тавьсан байжээ.

Нөлөөний хүрээг дахин эмхлэх гэсэн Герман, Зөвлөлтийн хэлэлцээр нь хоёр талын саналын зөрөлдөөнөөс болж эцэстээ нурав. Гитлер ЗХУ-ыг довтлохоор шийдэж алдарт “Барбаросса төлөвлөгөө”-ны тушаалаа буулгасан байв⁷³. Дөрвөн улсын хэлэлцээрийн урьдал нөхцөл болсон Германы зуучлал нь ийнхүү гэнэт бүтэлгүйтсэн ч Мацүока урьдын адил нөлөөллийн хүрээгээ дахин тодорхой болгохыг зорьсоор л байлаа.

11 сарын 18-ны өдөр Берлинээс Москвад буцаж ирсэн Молотов ЗХУ-д суух Японы элчин сайд Татэкаваг урьж, Японы талын гаргасан “Харилцан үл довтлох гэрээ” байгуулах асуудалд хариу өгчээ. Тэгэхдээ “ЗХУ нь алдсан газар нутгаа эргүүлэн авахгүйгээр харилцан үл довтлох гэрээ байгуулахыг бодохын аргагүй⁷⁴” хэмээн хэлж, оронд нь “Төвийг сахих гэрээ” байгуулах санал тавьсан байна. Улмаар харилцан үл довтлох гэрээ байгуулах тохиолдолд “Монгол, Шинжаан мэтийн Оросын талын алдсан газар нутгийг эргүүлэн авах тухай хөндөхгүй бол болохгүй⁷⁵” гээд Төвийг сахих гэрээ болон Хойд Сахалин дахь Японы эрх мэдлийг үгүйсгэхтэй холбоотой протоколыг элчин сайдад өгчээ.

Тэгвэл энд өгүүлж буй “Монгол” нь чухам аль газар нутгийг зааж байгаа юм бол? Тухайн үед Ар Монгол нь хэдийн ЗХУ-ын бүрэн нөлөөнд ороод байсан, 1912 оны “Япон, Оросын гурав дахь нууц гэрээ”-нд Өвөр Монголын баруун хэсгийг Оросын нөлөөний хүрээнд байлгах гэж заасан ч үнэн хэрэг дээрээ Японы мэдэлд ороод байсан, мөн “алдсан газар” хэмээн нэрлэж байсан зэргээс үзвэл Өвөр Монголын баруун хэсгийг зааж байх шиг санагдана.

⁷² Мөн тэнд, pp.322-325.

⁷³ Мөн тэнд, p.338.

⁷⁴ Өмнө дурдсан 『日本外交史21』 p. 273.

⁷⁵ Өмнө дурдсан 『日ソ中立条約一公開されたロシア外務省機密文書』、p. 71

Гэвч түүний дараа Мацүока Европтой дипломат харилцаа тогтоох зорилгоор зохиож 1941 оны 2 сарын 03-ны өдөр цэрэг засгийн зөвлөх хурлаар гаргасан “Герман, Итали, ЗХУ-тай хийх хэлэлцээрийн төсөл”-ийн хоёрдугаар зүйлд урьдын адил “Япон Улс ЗХУ-ын Шинжаан болон Гадаад Монгол дахь байр суурийг, ЗХУ нь Японы Хятадын хойд хэсэг болон Монгол хязгаар дахь байр суурийг хүлээн зөвшөөрнө. Шинжаан, Гадаад Монгол болон ЗХУ-ын харилцааг ЗХУ, Хятад хоорондоо шийдвэрлэнэ” гэж бичиж байв. Үүгээр зогсохгүй түүний нэгдүгээр зүйлд, ЗХУ-аар “Риббентропын төлөвлөгөө”-г зөвшөөрүүлэхийг Япон, Зөвлөлтийн гадаад харилцааг зохицуулахын урьдал нөхцөл болгож улмаар Германаар зуучлуулан дөрвөн улсын хэлэлцээр байгуулахыг төлөвлөж байжээ⁷⁶.

Бас “Дэлхийг, Их Зүүн Ази, Европ (Африкийг багтаасан), Америк, ЗХУ (Энэтхэг, Ираныг багтаасан) гэсэн дөрвөн бүсэд хуваан (Англид Австрали, Шинэ Зеландыг үлдээх), Япон Улс нь дайны дараах найрамдлын хурал дээр үүнийг бодит зүйл болгохыг санаачилна гэсэн Мацүокагийн том төлөвлөгөө дурдагдаж байв⁷⁷. Өөрөөр хэлбэл, Герман, ЗХУ-ын харилцаа муудаж, Мацүокагийн зураглаж ирсэн “Дөрвөн улсын холбооны онол” нь биелэх боломжгүй болсон хэдий ч Японы засгийн газар урьдын адил түүнд найдлага тавьсаар байжээ.

Үүний дараа Мацүока Европ орохдоо дайраад гарах хэлбэрээр Сталин болон Молотовтой хэлбэрийн төдий л хэлэлцээр хийж буцахдаа 4 сарын 07, 09, 11-ний өдөр нийт гурван удаа уулзаж ярилцжээ. Эхний уулзалтад гол төлөв хойд Сахалины эрхийн асуудлын талаар хэлэлцсэн ч хоёр талын санал дэндүү зөрүүтэй байсан тул шийдэлд хүрч чадаагүй. Хоёр дахь удаагийн уулзалт дээр Мацүока, “Нөлөөллийн хүрээний талаар нууц гэрээ байгуулах, түүндээ Өвөр Монгол, Хятадын хойд хэсгийг Японд, БНМАУ, Шинжааныг ЗХУ-ын нөлөөний хүрээ байхаар тогтоох” тухай шаардсан ч Молотов, “Сайн бэлдэх хэрэгтэй” гэдгээс өөр зүйл хэлэлгүй, үнэн хэрэгтэй хариулахаас татгалзсан байдаг⁷⁸. Гурав дахь удаагийн уулзалт нь БНМАУ, Манж Улсын асуудал байсан ч мөн л санал нийлээгүй.

Ийнхүү яриа хэлэлцээр нь бүтэлгүйтсэн ч удалгүй Сталин, Мацүока хоёр гэнэт уулзаж, хорин тавхан минутын дотор шийдвэр гаргажээ. Мацүокагийн ярьдаг, “Гадаад харилцааны цахилгаан дайн” энэ мэтээр үр дүнд хүрч, 4 сарын 13-ны өдөр “Япон-Зөвлөлтийн төвийг сахих гэрээ” байгуулагдсан ч олон асуудал дараатай хэвээр үлджээ.

4. Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн Халх голын дайны нөлөө

Өмнө өгүүлсэнчлэн, Халх голын дайны дараа Японы гадаад бодлогод томоохон өөрчлөлт оров. 1940 оны 7 сарын 27-ны өдрийн Цэргийн хамгийн дээд удирдах байгууллага болон Засгийн газрын зөвлөх хурал (Үүнээс хойш Цэрэг, засгийн зөвлөх хурал хэмээн товчилно)-аар батлагдсан “Дэлхийн нөхцөл байдлын шилжилтийг дагасан цаг үеийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр”-өөс тэр тухай харж болно. Түүнд, Ази дахь Европын колони орнуудын хувьд, эзэн улс нь

⁷⁶ Хуурай Газрын Цэргийн Яамны баримт. 中央一戦争指導重要国策文書一1128. Японы Батлан Хамгаалах Яамны архив.

⁷⁷ Мөн тэнд.

⁷⁸ Өмнө дурдсан 『日ソ中立条約一公開されたロシア外務省機密文書』、pp. 107-109.

Германтай дайтан хүч нь суларсныг далимдуулан колони орноо дахин хуваах тухай чиглэл дурдагдаж түүнээс хойш Японы сонирхол Номхон далай руу чиглэжээ⁷⁹.

1941 оны 6 сарын 22-ны өдөр Герман нь ЗХУ-руу гэнэт дайран Зөвлөлт-Германы дайн үүсэв. Японы хамгийн дээд удирдлага энэхүү олон улсын нөхцөл байдлын таатай өөрчлөлтийг ашиглан, Зөвлөлтийн зүүн хэсэг рүү довтлох уу? эсвэл урагшаа довтлох уу гэсэн сонголттой тулгарчээ. Японд өдөр бүр Цэрэг, засгийн зөвлөх хурлыг хуралдуулж, Зөвлөлт, Германы дайны хажуугаар Япон ямар байр суурьтай байхыг хэлэлцжээ. “Япон- Зөвлөлтийн төвийг сахих гэрээ”-нд голлох үүрэгтэй оролцсон Мацуока нь ЗХУ руу довтлохыг чухалчилдаг хүмүүсийн нэг байсан бол Сүгияма (杉山) тэргүүтэй Төв штабынхан харин түүнийг эсэргүүцэж байжээ⁸⁰.

7 сарын 02-ны өдөр “Нөхцөл байдлын шилжилтийг дагасан Эзэнт гүрний төрийн бодлогын хөтөлбөр” ширүүн маргааны эцэст батлагджээ. Түүнд, “Өмнө зүгт дайлах” хэмээн бичигдэж бай⁸¹. Түүний зэрэгцээгээр бас “Герман-Зөвлөлтийн дайн Япон Улсад ашигтайгаар эргэвэл зэвсгийн хүч ашиглан хойд арлуудын асуудлыг шийдвэрлэж, хойд хязгаарын тогтвортой байдлыг буй болгоно” хэмээн бичиж, ЗХУ-т довтлохоо бүр мөсөн орхиогүй байв.

Тожо Хидэки (東条英機) ч тухайн үед “ЗХУ нь боловсорсон жимс шиг газар унах” үед нь довтлох бодлоготой байжээ. Японы хуурай газрын цэрэг “Квантуны арми нь Сибирь дэх улаан армиас гурав дахин хүчтэй болсон үед”, эсвэл “Дайнд ЗХУ ялагдан Сибирийн улаан арми дотроосоо задрах нь тодорхой болсон үед” Зөвлөлт рүү довтлох төлөвлөгөөтэй байв. Энэ мэдээллийг олж авсан домогт тагнуулч Зорге ЗХУ-д хандан 1941 оны 7 сарын 30-ны өдөр “Москва эзлэгдвэл Япон дайнд оролцоно⁸²” гэж мэдээлж байжээ. Үүний өмнөхөн 6 сарын 24-ний өдөр батлагдсан, “Нөхцөл байдлын шилжилтийг дагасан Эзэнт гүрний төрийн бодлогын хөтөлбөрийн цэргийн хамгийн дээд удирдах байгууллагын тэнгисийн цэргийн төсөл”-д ч хойд нутгийн асуудлын тухай “Герман ЗХУ-ын дайн нь Япон Улсад ашигтайгаар эргэвэл зэвсгийн хүч ашиглан, хойд талын асуудлыг шийдэж, хойд хязгаараар тогтвортой байдлыг буй болгоно” хэмээн ЗХУ руу довтлох төлөвлөгөөгөө бүр мөсөн орхиогүй байв⁸³.

Гэвч түүний дараа Герман Улс дайнд илэрхий ялалт байгуулж, өвөл болоход Москвагаас 70-хан км-т тулан хүрч нийслэлийг нь эзлэх шахсан байдаг. Тийм байтал хамгийн сүүлд Япон нь ЗХУ руу довтлоогүй. Үүгээр барахгүй тухайн үед Герман нь тасралтгүй Японыг довтлохыг ятгасаар байсан гэдэг. Японы хувьд авч үзвэл энэхүү байдал нь урд өмнө байгаагүй том завшаан атал Япон нь “өмнө зүг” рүү л довтлохыг баримталсаар байв. Шалтгаан нь юу байв? Тожо Хидэкигийн хэлсэнчлэн цаг хугацаа нь бас “боловсорсон жимс” болоогүй байв уу? Эсвэл “Япон Зөвлөлтийн төвийг сахих гэрээ”-нд заасан хариуцлагадаа баригдав уу? Эсвэл Халх голын дайны цочролоос болов уу?

⁷⁹ 森山優「「南進論」と「北進論」」倉沢愛子ほか編『支配と暴力』岩波書店、2006年、p. 194。

⁸⁰ ボリス・スラブィンスキ『日ソ戦争への道—ノモンハンから千島占領まで』（加藤幸広訳）共同通信社、1999年、pp. 238-240。

⁸¹ 外務省『日本外交年表並主要文書（下）』原書房、1965年、pp. 531-532。

⁸² Өмнө дурдсан『日ソ戦争への道—ノモンハンから千島占領まで』、pp. 241-250。

⁸³ 防衛庁防衛研修所戦史室『関東軍2』（関特演・終戦時の対ソ戦）朝雲新聞社、1974、p. 9。

Халх голын дайнд биеэр оролцсон Инада Масазүми (稲田正純) “Зөвлөлтийн Алс Дорнодын армитай хийсэн тулалдаан”- даа түүний шалтгааныг Халх голын дайны ялагдлаас эрж, Халх голын дайн нь Японы стратегийг өөрчилсөн хэмээн бичсэн байна. Тухайн үед Германы Японд суугаа элчин сайд Отто, Гадаад хэргийн сайд Риббентропт илгээсэн цахилгаан мэдээндээ Японы цэргийнхэн улаан армитай тулалдах чадвартаа эргэлзэн, ялах итгэлгүй байна. Ялангуяа Квантуны армийн командлагчид тийм хандлагатай байгаа бөгөөд энэ нь Халх голын дайнаас үүдэлтэй байх хэмээн тайлбарласан байв⁸⁴.

Эсрэгээр нь хэлбэл, Халх голын дайн болоогүй бол Германы ятгалга болон дайны олзонд татагдан ЗХУ руу довтлох бүрэн бололцоо байжээ гэсэн үг. Улмаар, хэрэв ЗХУ руу довтолсон бол Сувдан эрэг рүү дайрахгүй байсан ч байж магадгүй. Өөрөөр хэлбэл, Номхон далайн дайн болохгүй байсан байж магадгүй. Хэрэв Номхон далайн дайн болоогүй байсан бол Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөн ч өөр замаар явах байсан ч байж магадгүй. Энэ нь хэдийгээр таамаг төдий боловч Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөнд үзүүлсэн Халх голын дайны нөлөөг ярихад чухал сэдэв гэж бодогдоно.

Гэхдээ бодит байдал эсрэгээр болсон байдаг. Халх голын дайн нь Японы дайны стратегийг уламжлалт “Умард зүг дайлах бодлого”-оос “Өмнө зүг дайлах бодлого”-т *шилжих нэг шалтгаан болсноор барахгүй түүний* үр дүнд нь Номхон далайн дайн гарсан бөгөөд үүнээс үүдэн Японы “Умард зүг дайлах бодлого” гэх дэлхийн стратегийн дотор боловсруулагдсан Өвөр Монголын асуудалд геополитикийн хувьд томоохон өөрчлөлт гарсан байдаг. Түүнээс хойш “Өмнө зүг дайлах бодлого”-ын хэрэгжүүлэхийг дагалдан Зүүн өмнөд Азийн бүс нутгийн асуудал нь Өвөр Монголын асуудлыг орлож, үр дүнгийн хувьд тус бүс нутгийн үндэстнүүдийн тусгаар тогтнолын хөдөлгөөнтэй холбогдсон билээ.

Зүүн өмнөд Азийн нутгийн тусгаар тогтнолын асуудлын талаар олон судалгаа байдаг⁸⁵ учраас энд би нэг нэгээр танилцуулахгүй. Зөвхөн нэг л жишээ татъя.

Номхон далайн дайны өмнө барууны орны колони болж, янз бүрийн хэлбэрээр хүнд хэцүү тэмцлийг үргэлжлүүлж байсан Зүүн өмнөд Азийн орнуудын үндэстний тусгаар тогтнох хөдөлгөөн нь тэрхүү дайн хийгээд дайны үед тэдгээр улсад нэвтрэн орсон Японы нөлөөгөөр эдгээр шинэ нөхцөл байдлыг бие даан идэвхтэйгээр шийдвэрлэж илт амжилт гаргасан байдаг. Тэгээд тэрхүү амжилт нь Номхон далайн дайны дараа, өөрөөр хэлбэл, Дэлхийн хоёрдугаар дайны дараа Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн хөдөлгөөн, цаашилаад улс орнуудын тусгаар тогтноход шийдвэрлэх хүчин зүйл болсон байдаг. Үнэндээ Номхон далайн дайн хийгээд Японы түрэмгийлэл нь Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн тусгаар тогтнох хөдөлгөөнд томоохон эргэлт болсон гэж хэлж болно⁸⁶.

⁸⁴ Өмнө дурдсан. The Influence of Khalkhin Gol on the Outbreak. Conduct. and Outcome of World War II.

⁸⁵ 信夫清三郎『太平洋戦争と「もう一つの太平洋戦争」』勁草書房、1988年、後藤乾一『近代日本と東南アジア』岩波書店、1995年、谷川栄彦「太平洋戦争と東南アジア民族独立運動」『法政研究』(53:3)、1987年 мэт судалгааны зүйл буй.

⁸⁶ Өмнө дурдсан「太平洋戦争と東南アジア民族独立運動」、p.362.

Дүгнэлт

Энэ өгүүлэлдээ Япон болон ЗХУ-ын харилцаанд тулгуурлан, Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөн өрнөж байх үеийн олон улсын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийг зорив. Манж улс бий болсноос эхэлсэн Япон-ЗХУ, Манж-Монголын хилийн мөргөлдөөн нь 1935 оноос ихээр олширсон байв. Халхын сүмийн хэрэг явдал бол түүний ганцхан жишээ юм. Дараа нь Манжуурын хэлэлцээр болж, асуудлыг шийдвэрлэхийг зорьсон боловч аль аль тал нь ч өөр өөрийн байр суурьтай байснаас болж бүтэлгүйтэж, ЗХУ-Японы харилцаа нь улмаар муудсан байна. Тэр нь цэргийн явдлын талаар хил хамгаалалтыг чангатгах, гадаад харилцааны талаар холбоо байгуулах байдлаар илэрч байв. “Монгол-Зөвлөлтийн харилцан тусалцах протокол” (1936), “Хятад-ЗХУ-ын харилцан үл довтлох гэрээ” (1937) нь үүний тод жишээ билээ. Үүнийг нь эсэргүүцэн Япон нь “Хиротагийн гурван зарчим”-ынхаа араас “Коммунизмын эсрэг шугам” байгуулах аргаар “Улааны зам”-ыг таслан зогсооно гэсэн төлөвлөгөө гарган, 1936 оны 11 сард “Япон-Германы коммунизмын эсрэг гэрээ” улмаар 1940 оны 9 сард Итали Улсыг нэмэн “Гурван улсын холбоо”-г байгуулав.

Япон, ЗХУ-ын Конфронтейшн айхсис (Confrontation axis) ийнхүү бүрэлдэн тогтож тухайн үед Өвөр Монголын бүс нутаг нь геополитекийн хувьд яг түүний төвд байсан учраас хоёр талаас цохилон ирэх мөргөлдөөний энергийг хураан авч эцэстээ Өвөр Монгол нь Японы дэлхийн стратегийн дунд коммунизмын эсрэг түшиц газар болж илэрсэн байдаг. Үүнээс үүдэн Японы гадаад бодлогод Өвөр Монголын асуудал чухалчлагдан салган тусгаарлах ажиллагаа эрчимжив. Итагаки Сэйшироү (板垣征四郎)-ийн Өвөр Монголын тусгаар тогтнолын тухай илтгэл, тусгаар улс байгуулахаар эцсийн зорилгоо болгосон Монгол цэргийн засгийн газар байгуулагдсаны цаана нь иймэрхүү олон улсын динамик нөхцөл байдал байжээ.

Гэвч дараа нь Халх голын дайн ба Зөвлөлт Германы “Харилцан үл довтлох гэрээ” зэрэг олон улсын нөхцөл байдлаас шалтгаалан Японы дэлхийн стратегийн бодлогод эргэлт гарч “Өмнө зүг дайлах бодлого” голлон сонирхол нь Өвөр Монголоос Номхон далай руу ялангуяа Зүүн өмнөд Ази руу шилжсэн байна. Энэ нь Өвөр Монголын асуудлын геополитикийн ач холбогдол нь өөрчлөгдсөн гэсэн үг юм. Энэ хүртэлх Зүүн Азийн орны дэлхийн улс төрийн нөхцөл байдал Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөнд нааштай зүйл байсан бол шинэ бодлогын улмаас эсрэгээр эргэсэн байдаг. Монголын холбон нийлэлдэж өөртөө засах засгийн газар байгуулагдаж, Өвөр Монголын Өөртөө засах хөдөлгөөн нь бууралтын шаганд орсны гадаад шалтгаан нь энэ юм. Тухайн үед “Япон-ЗХУ-ын төвийг сахих гэрээ” байгуулагдахад Гадаад хэргийн сайд Мацүока ЗХУ-д хандан Японы Өвөр Монгол дахь нөлөөллийн хүрээг хүлээн зөвшөөрөхийг шаардаж байсан нь үнэндээ үүнээс илүү Өвөр Монголын асуудалд хутгалдахыг хүсээгүйн илэрхийлэл байсан байж болох юм.

Товчхон хэлбэл, Япон болон Зөвлөлт хоёр улсын харилцааны түүхэнд холбогдох Халхын сүмийн хэрэг, Халх голын дайн, ЗХУ, Германы “Харилцан үл довтлох гэрээ”, “Дөрвөн улсын холбооны онол”, ЗХУ-Японы “Төвийг сахих гэрээ” зэрэг түүхэн хэрэг явдлуудын аль аль нь тухайн үеийн Өвөр Монголын асуудалд зохих хэмжээний нөлөө үзүүлж байжээ хэмээн хэлж болно.

Abstract

論文要約

本稿では、地理的な関係により、いわゆる「モンゴル問題」に多大な影響を与えてきた日ソ両国の外交関係におけるハルハ廟事件、ハルハ河戦争、四国同盟論など一連の出来事が内モンゴル自治運動において、いかなる影響を与えたかという問題を分析することによって、当時の国際関係の中の内モンゴル問題のあり方を明らかにした。

Ном зүй**Архивын баримт**

1. Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. А-6-1-2. Гадаад Хэргийн Яамны архив
2. Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. А-1-1-0, Японы Гадаад Хэргийн Яамны архив.
3. Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. В-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив.
4. Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. В-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив.
5. Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. В-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив
6. Гадаад Хэргийн Яамны тэмдэглэл. А-1-0-0. Японы Гадаад Хэргийн Яамны архив
7. Батлан Хамгаалах Яамны баримт. 陸軍省-陸満密大日記-S11-9-41. Японы Батлан Хамгаалах Яамны архив.
8. Хуурай Газрын Цэргийн Яамны баримт.中央一戦争指導重要国策文書-1088. Японы Батлан Хамгаалах Яамны архив.
9. Хуурай Газрын Цэргийн Яамны баримт. 中央一戦争指導重要国策文書-1128. Японы Батлан Хамгаалах Яамны архив.

Баримтын эмхэтгэл

5. 外務省『日本外交年表並主要文書（上）』、原書房、1965年。
6. 外務省『日本外交年表並主要文書（下）』原書房、1965年。
7. 外務省『日本外交文書』（第二次欧州大戦と日本 第一冊 日独伊三国同盟・日ソ中立条約）六一書房、2012年。
8. 防衛庁防衛研修所戦史室『関東軍1』（対ソ戦備・ノモンハン事件）朝雲新聞社、1969年。
9. 防衛庁防衛研修所戦史室『関東軍2』（関特演・終戦時の対ソ戦）朝雲新聞社、1974年。
10. 堀内謙介『日本外交史21』（日独伊同盟・日ソ中立条約）鹿島平和研究所、1971年。
11. 『大戦の秘録-独外務省の機密文書より』（邦訳）読売新聞社、1948年。
- 12.

Судалгааны бүтээл

1. 牛島康允『ノモンハン全戦史』自然と科学社、1989年。
2. ガンバガナ「モンゴル自治邦の実像と虚像」『中国21』（27）、2007年。
3. ガンバガナ「内モンゴル自治運動と太平洋戦争期における日本の対内モンゴル政策について-「日華同盟条約」を中心に」『東北アジア研究』（16）、2012年。
4. 後藤乾一『近代日本と東南アジア』岩波書店、1995年。
5. 小林幸男『日ソ政治外交史-ロシア革命と治安維持法』、有斐閣、1985年、p.65。
6. 斎藤二郎『支那をめぐる日ソ英米』今日の問題社、1936年。
7. 酒井哲哉「日米開戦と日ソ関係」、細谷千博ほか編『太平洋戦争』東京大学出版会、1993年。
8. 信夫清三郎『太平洋戦争と「もう一つの太平洋戦争」』勁草書房、1988年。
9. 鈴木武雄「大陸ルート論」『アジア問題講座第三巻』創元社、1940年。

10. 谷川栄彦「太平洋戦争と東南アジア民族独立運動」『法政研究』（53:3）、1987年。
11. 天冲郷廟『日ソの危機を探る』今日の問題社、1936年。
12. 千葉山男『極東赤化の現段階と中国共産党の動向』辺境問題研究所、1935年。
13. 辻政信『モンハン秘史』毎日ワNZ、2009年。
14. 中見立夫『「満蒙問題」の歴史的構図』、東京大学出版会、2013年。
15. 中山正夫『ソ連側資料からみたノモンハン事件』防衛研修所、1978年。
16. 判澤純太「ノモンハン事件と国際環境」『政治経済史学』（252）、1987年。
17. 半藤一利『ノモンハンの夏』文芸春秋、2001年。
18. ポリス・スラヴィンスキ『日ソ中立条約—公開されたロシア外務省機密文書』岩波書店、1996年。
19. ポリス・スラヴィンスキ『日ソ戦争への道—ノモンハンから千島占領まで』（加藤幸広訳）共同通信社、1999年。
20. 日森虎雄「赤色ルート論」『アジア問題講座第三巻』創元社、1940年。
21. マンダフ・アリウンサイハン「満洲里会議に関する一考察」『一橋論叢』（778）、2005年。
22. 三浦信行ほか「日露の資料で読み解く「ノモンハン事件」の一側面」『アジア・日本研究センター紀要』（5）、2010年。
23. 森山優「「南進論」と「北進論」」倉沢愛子ほか編『支配と暴力』岩波書店、2006年。
24. 森山康平『はじめてのノモンハン事件』PHP研究所、2012年。
25. Stuart D. Goldman., The Influence of Khalkhin Gol on the Outbreak. Conduct. and Outcome of World War II. 今西淳子, ボルジギン・フスレ編『ノモンハン事件70周年—バートル国際シンポジウム報告論文書』風響社、2009年。
26. Stuart D. Goldman, Nomonhan, 1939: *The Red Army's Victory That Shaped World War II*, Naval Institute Press, 2013.
27. Р.Болд, *Зарлаагүй дайн: Халхын голын байлдааны цэрэг-дипломатын түүх*, Непко хэвлэлийн газар, УБ, 2014.